



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/50

Номгон

“Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийг
2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах
тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн “Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөр батлах тухай 122 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлж, хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг Архивын тасаг (В.Эрдэнэчимэг)-т, дагаж мөрдөж ажиллахыг нийт байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310123